



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 461

Улаанбаатар хот

### Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 6.2.1, 6.3.3, 6.4.6 дахь заалт, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 9/20 дугаар тогтоол, Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний А/461 дүгээр захирамж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 46 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,706,368.52 (нэг сая долоон зуун зургаан мянга гурван зуун жаран найман төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий үл хөдлөх хөрөнгө (орон сууц) нь Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 9/20 дугаар тогтоолоор нийтийн орон сууцны барилгын дахин төлөвлөлтөд хамрагдсан тул данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Дахин төлөвлөлтөд хамрагдсан хөрөнгийн нөхөн олговор (хөнгөлөлт, санхүүжилт) болох нийт 74,900,000.00 (далан дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 10 дугаар багийн Таван-Эрдэнэ 25/2 дугаар байрны 6 дугаар давхрын 31 тоотод байрлах 50.05 м.кв талбай бүхий орон сууцны 2 өрөө байрыг Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Үл хөдлөх хөрөнгө (орон сууц)-ийг акталж, данснаас хасах болон бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3.Энэхүү тогтоолыг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж, төрийн өмчийн өмчлөх эрх үүссэнийг мэдэгдэх.

3.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

